



СҮРЭНЖАВЫН БАЛБАР

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга
1972-1976 он

Хуучин Түшээт хан аймгийн Хангай хайрхан уулын хошуу, одоогийн Архангай аймгийн Хашаат сумын нутагт малчин ард Сүрэнжавын гэр бүлд 1936 онд төржээ. Тэрбээр 1947-1957 онд Улаанбаатар хотын арван жилийн нэгдүгээр дунд сургууль, 1957-1962 онд ЗХУ-ын Москва хотын Инженер эдийн засгийн дээд сургуулийг инженер эдийн засагч мэргэжлээр суралцаж төгссөн.

1962-1965 онд Улсын төлөвлөгөөний комиссын их барилгын хэлтсийн мэргэжилтэн, 1965-1972 онд мөн газрын хэлтсийн дарга, Улсын төлөвлөгөөний комиссын орлогч дарга, 1972-1976 онд Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга, 1976-1978 онд шинээр байгуулагдах Атарын сангийн аж ахуйнуудыг зохион байгуулах Намын Төв Хороо, Засгийн

газрын төлөөлөгч, 1978-1984 онд Монгол-Зөвлөлтийн Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсгийн орлогч дарга, 1984-1987 онд Төв аймгийн Барилга конторт барилгын даамлаар томилогдон ажиллаж байгаад биеийн эрүүл мэндийн байдлын улмаас чөлөөлөгджээ.

БНМАУ-ын АИХ-ын найм дахь удаагийн сонгуулиар АИХ-ын депутат, орон нутгийн АДХ-ын депутат, орон нутгийн АДХ-ын 9-10 дахь сонгуулиар Улаанбаатар хотын АДХ-ын депутатаар сонгогдож байжээ.

Түүний ажлын үр бүтээлийг үнэлж “Алтан гадас” одон, бусад медалиудаар шагнажээ. 1972 онд Улаанбаатар хотыг хөгжүүлэх гурав дахь удаагийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад биечлэн оролцож, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, 1972-1976 онд орон сууцны шинэ хороолол, соёл үйлчилгээний төв, кино театр, сургууль цэцэрлэг, ясли, гэрлэх ёслолын ордон, залуу техникчдийн ордон, хотын хойд тойргийн усан сан, дулааны цахилгаан станцын өргөтгөл барих, Толгойтын чиглэлийн засмал зам тавих, Энхтайваны гудамжны зарим нэгдүгээр давхрыг үйлчилгээний газар болгох, тохижуулах зэргээр хотын өнгө үзэмжийг дээшлүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад анхаарч ажиллажээ.

Хотынхоо ойг анх удаа тэмдэглэж, хотдоо одон зүүлгэсэн анхны дарга юм.